



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 64

Дархан

Мал нэвтрэхийг хориглосон нутаг
дэвсгэрийн бүсчлэл тогтоох, мөрдөх
журам батлах тухай

Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1, 62.2 дахь заалт, “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4 дэх заалт, “Хот байгуулалтын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 99 дүгээр тогтоол, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Орон сууц, олон нийтийн бүс, Үйлдвэрийн бүс, Инженер шугам сүлжээ болон зам тээврийн бүс, Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүсийн зураглал”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Мал нэвтрэхийг хориглосон нутаг дэвсгэрийн бүсчлэлд мөрдөх журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хагас, бүтэн жилээр ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг Дархан сумын Засаг дарга /Л.Тулгаа/, аймгийн НААҮГ-ын дарга /З.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА  Я.БАТ-ОЧИР

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2021 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн
64 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



МАЛ НЭВТРЭХИЙГ ХОРИГЛОСОН НУТАГ ДЭВСГЭРИЙН БҮСЧЛЭЛД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Дархан сумын мал нэвтрэхийг хориглох бүс нь байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, хүн амьдрах эрүүл ахуйн шаардлага хангасан орчин бий болгох, ач холбогдолтой нутаг дэвсгэр мөн бөгөөд тус сумын эдэлбэр газрыг зүй зохистой ашиглах, хотын ногоон байгууламжийг хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, эзэн хариулгагүй малыг эрсдлээс хамгаалах зорилгоор мал нэвтрэхийг хориглосон бүсэд нэвтрэн орсон малыг хашиж, түүнтэй холбоотой гарсан зардлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

Хоёр. Мал нэвтрэхийг хориглосон нутаг дэвсгэрийн бүсчлэл

2.1. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бүсчлэлд:

ОРОН СУУЦ, ОЛОН НИЙТИЙН БҮС:

- 1-р хэсэг: Төмөрлөгийн үйлдвэр руу эргэдэг авто замын уулзвараас Дархан-Улаанбаатарын авто зам, төмөр замын хоорондох 3-н шарын хэсэг
- 2-р хэсэг: Дархан сумын 5-15 дугаар багт байрлах сууршлын бүс, гэр хороолол болон барилгажсан хэсэг

ҮЙЛДВЭРИЙН БҮС:

- 1-р хэсэг: Дархан сумын хилийн цэсийн шугамаас хойшоо үйлдвэрийн районы авто зам хүртэл. Үйлдвэрийн бүс бүхэлдээ, ДДЦС-ын үнсэн сан
- 2-р хэсэг: Дархан сумын 3-р багийн барилгажсан хэсэг, Малчин багийн хилийн цэсийн шугамаас хойшоо Дархан сумын хойд хилийн шугам хүртэл, цэвэрлэх байгууламж, тоосгоны үйлдвэрүүд

ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ БОЛОН ЗАМ ТЭЭВРИЙН БҮС:

- Дархан сумын урд хилийн шугамаас хойшоо төмөр замын дагуу Дархан сумын хойд хилийн цэсийн шугам хүртэл зурвас хэсэг

НОГООН БАЙГУУЛАМЖ, АМРАЛТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС:

- Төмөр замаас баруун тийш Хараа гол, 1,2 дугаар багийн урд талын үерийн далангаас урагшаа Дархан сумын хилийн цэсийн шугам хүртэл, голын ай сав, болон үйлдвэрийн районы авто

замаас хойшоо цэвэр усны сан байрлах толгод бүсэд мал оруулахыг хориглоно.

Гурав. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

3.1 Мал нэвтрэхийг хориглох бүсэд мөрдөх журамд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох.

3.2 Журмын хэрэгжилтийн талаарх сумын Засаг даргын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланд үнэлэлт дүгнэлт өгөх.

Дөрөв . Малчин, мал бүхий этгээдийн эрх, үүрэг

4.1 Малчин, мал бүхий этгээдийн эрх:

4.1.1. Малыг хашиж журамлах хугацаанд үзүүлсэн үйлчилгээ, бүртгэл, тэмдэглэл, баримт материалтай танилцах.

4.2 Малчин, мал бүхий этгээдийн үүрэг:

4.2.1 Мал нэвтрэхийг хориглосон бүсэд нэвтрэн оруулахгүй байх бүх талын арга хэмжээг авах.

4.2.2 Малчин, мал бүхий этгээд нь өөрийн малыг хашсан хашаанд байгааг мэдмэгц түр хаших хашаанаас гаргах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх.

4.2.3 Малыг хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг нөхөн төлөх.

4.2.4 Хууль тогтоомжид заасан бусад шаардлагыг биелүүлэх.

Тав. Малыг хашиж журамлах үйл ажиллагаа

5.1 Энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1.-д заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд НААҮГ нь малыг хашиж журамлах ажлыг зохион байгуулалтаар хангана.

5.2 Мал оруулахыг хориглосон бүсчлэлд орсон малыг НААҮГ-ын зам талбайн ажилчид, Дархан сумын ЗДТГ-аас томилогдсон нийтийн эргүүл нь журмын хашааны ажилтанд малын нэр төрөл, хүйс, зүс, тоо, хүлээн авсан цаг хугацаа, малын шинж тэмдгийг нэг бүрчлэн бичиж бүртгэл үйлдэн хүлээлгэн өгсөн этгээдээр гарын үсгийг зуруулж баталгаажуулан хүлээлцэнэ.

5.3 Журамлагдан ирсэн малыг эрүүл ахуйн шаардлага хангасан газарт мал хаших зориулалтын хашаанд хаших бөгөөд мал эмнэлгийн нэгжийн эмч үзлэг хийнэ.

5.4 Хашиж журамлагдсан мал бүрт хоногт хоёроос доошгүй ус, тэжээл өгч тухай бүрт бүртгэл үйлдэнэ.

5.5. Ажлын бус цагаар журамлагдан ирсэн мал нь гадны ямар нэг гэмт халдлагад өртсөн шинж тэмдэгтэй байж болзошгүй нөхцөлд НААҮГ-ын холбогдох ажилтан шинж тэмдэг бүрийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, зургаар баримтжуулан хүлээлгэн өгсөн этгээдээр гарын үсэг зуруулах бөгөөд дараа өдрийн ажлын цаг эхэлмэгц нэн яаралтай малын эмч үзлэг хийнэ.

5.6 Энэ журмын 5.3-5.5 дахь заалтуудын дагуу ажилласан нөхцөлд тухайн мал түүнээс гарсан төл хорогдвол хашиж журамласан байгууллага, ажилтан хариуцлага хүлээхгүй.

5.7 Хорогдсон малыг 24 цагийн дотор НААҮГ-ын холбогдох ажилтан малын эмчид, малын эмч байхгүй тохиолдолд сумын мал эмнэлгийн тасагт мэдэгдэж дүгнэлт, акт гаргуулна.

Зургаа. Нийтэд зарлан мэдэгдэж малын эзнийг тодруулах

6.1 Дархан сумын Засаг даргын тамгын газар нь хашиж журамлагдсан малын эзнийг тогтоогдох хүртэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулах бөгөөд үүнтэй холбогдон гарсан зардлыг тэдгээрийн эзэн хариуцагчаас гаргуулна.

6.2 Хашиж журамлагдсан малын эзнийг тогтоохоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулснаас хойш 72 цагийн дотор эзэн нь тогтоогдоогүй тохиолдолд харьяа цагдаагийн байгууллагад бүртгүүлэх ба цагдаагийн байгууллагаас эзэн хариуцагчийг тогтоох ажлыг хийж гүйцэтгэнэ.

6.3 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсны дагуу малаа авахаар ирсэн иргэний бичиг баримтыг үзэж малын тоо, зүс, нас, им, тамга зэрэг бусад содон шинж тэмдгийг асууж тодруулсны үндсэн дээр шинж тэмдэг тохирсон тохиолдолд тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

6.4 Малыг зөвхөн эрх зүйн чадамжтай этгээдэд зохих хариуцлага тооцож, хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг бүрэн төлсний дараа Дархан сумын Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтнаас олгосон зөвшөөрлийн бичгийн үндсэн дээр хүлээлгэн өгнө.

Долоо. Малыг хашиж журамлахтай холбогдон гарсан зардал, түүнийг нөхөн төлүүлэх

7.1 Хашиж журамлагдсан малын эзнийг тодорхой болтол тэдгээрийг хадгалж, арчилж хамгаалахтай холбогдон гарсан зардлыг малчин, мал бүхий этгээдээр төлүүлнэ.

7.2 Малыг хашиж журамлахтай холбогдон гарсан зардал гэдэгт:

7.2.1 Малыг туух зорилгоор машин техник ашигласан бол тэдгээрийн түлшний зардал

7.2.2 Өвс, тэжээл, усны зардал

7.2.3 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан зардал

7.2.4 Мал эмнэлэгийн газраас үзүүлсэн эмчилгээ, үйлчилгээний зардал

7.2.5 Мал, амьтныг туух, хаших, хамгаалах үүрэг бүхий ажилтан, албан хаагчдад олгох урамшуулал.

7.2.6 Малыг хаших, хадгадах, хамгаалахтай холбогдон гарсан бусад зардал

7.3 Малыг хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг бог мал нэг бүрт 5000 төгрөг, бод мал нэг бүрт 10000 төгрөгөөр, хоног тутамд бог мал нэг бүрт 15000 төгрөг, бод мал нэг бүрт 30000 төгрөгөөр тооцож нөхөн төлүүлнэ.

7.4 24 цагаас дээш хугацаанд хашиж журамлагдсан малыг туух, хаших, хадгалах, хамгаалахтай холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэхдээ энэ журмын **7.3-т** заасан нөхөн төлвөл зохих мөнгөн дүнг давхардуулан төлүүлэхгүй.

7.5 Журмын 7.3-т заасан зардлыг мөнгөн хэлбэрээр төлөх боломжгүй тохиолдолд малыг зах зээлийн ханшаар тооцон улсын орлого болгох замаар нөхөн төлүүлнэ.

7.6 Мал, тэжээвэр амьтан нэвтрэхийг хориглосон бүсэд мал, амьтан орсныг холбогдох байгууллагад баримтжуулж мэдээлсэн иргэнд бог мал нэг бүрээс 1000 төгрөг, бод мал нэг бүрээс 2000 төгрөгөөр тооцож урамшуулал олгоно.

7.7 Энэ журмын 7.6-д заасан урамшууллыг иргэнд олгох ажлыг Нийтийн аж ахуй үйлчилгээний газар хариуцна.

7.8 Мал, амьтныг хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг Дархан хотын тохижилт үйлчилгээний газар хаан банк 5108363490 тоот Төрийн сангийн нэмэлт дансанд төвлөрүүлнэ.

7.9 Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын Төрийн сангийн нэмэлт дансанд хуримтлагдсан мөнгийг энэ журмын 7.2-т заасан зардалд болон ногоон байгууламжийг нөхөн сэргээхэд зарцуулна.

Найм. Гомдол гаргах эрх

8.1 Тухайн малчин малыг хашиж журамлах үйл ажиллагаа, түүнтэй холбоотой гарсан зардал, хохирол нөхөн төлүүлэх шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо Дархан сумын Засаг даргын тамгын газарт гаргана.

8.2 Гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна.

8.3. Тухайн байгууллага гомдлыг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд малчин гомдлоо шүүхэд гаргаж болно.

Ес. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1 Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.2. Малыг хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг төлсөн нь захиргааны хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Арав. Журмын мөрдөх хугацаа

10.1 Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

---oOo---